



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

“Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК-ийн  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

“Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК нь брокер, дилер андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулаагүй, хувь нийлүүлсэн хөрөнгийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй, боловсон хүчний шаардлагыг хангаагүй, тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаж, тусгай зөвшөөрөл сэргээлгэх хүсэлтээ ирүүлээгүй зэрэг зөрчлүүдийг тэмдэглэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дах заалт болон Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 11.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Юнайтэд секьюритс ҮЦК” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийлгэхийг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

00087a